



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/155

Мандалговь

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөнөөс орон
нутгийн төсөвт төвлөрсөн мөнгийг зарцуулах тухай

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 7 дугаар бүлгийн 31 дүгээр зүйлийн 8, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын хавсралт "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан журмын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг дарын 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар хуралын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрөөс орон нутгийн төсөвт төвлөрсөн хавсралтын дагуу зарцуулахыг аймгийн Цэргийн штабын даргад даалгасугай.

Хоёр. Шаардагдах 15.681.900 /арван таван сая зургаан зуун наян нэгэн/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга О.Чулуунбат, нягтлан бодогч Ц.Даваа нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

000000471

Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дугаар сарын
19 ны едрийн 1/25 дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөнөөс орон нутгийн төвлөрсөн
мөнгөний зарцуулалтын хуваарьлалт

| д/д | Зарцуулалт | Юунд зарцуулах | Мөнгөн дүн /төгрөгөөр/ |
|------|---|---|------------------------|
| 1 | МУ-ын ЗГ-ын 2016 оны 215 дугаар тогтоолын 4.1.5 дахь заалт, Говийн бүсийн ЗДТГ-ын дарга нарын цэргийн бэлтгэл сургалт, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх | а/ Говийн бүсийн аймгуудын ЗДТГ-ын дарга нарын цэргийн бэлтгэл сургалт зохион байгуулахад | 5.000.000 |
| | | б/ Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд | 2.000.000 |
| | | в/ Сумын батлан хамгаалах товчооны бэлэн байдлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 1.000.000 |
| 2 | Цэргийн штабын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | а/ Монгол цэрэг-Дэлхийн цэрэг өдөрлөг, ЭСА-нд оролцогсодод хүндэтгэл үзүүлэх, шагнаж урамшуулах | 331.900 |
| | | ЭСА-нд оролцогсодын баярыг тохиолдуулан Дундговь аймгаас төрөн гарсан генералуудад хүндэтгэл үзүүлэх, шагнаж урамшуулах | 550.000 |
| | | б/ ЗХ-ний 96 жилийн үйл ажиллагааг зохион байгуулж явуулахад | 800.000 |
| | | в/ Тээвэр шатахуунд | 3.000.000 |
| | | Цэрэг татлагын үеэр Батлан хамгаалах багц хуулиуд Гэрээт цэргийн албыг сурталчилах зорилгоор Дуурьсал хамтлаг, Тэнгэрийн тэмдэг театртай хамтран тоглолт зохион байгуулах | 1.000.000 |
| | | г/ ЦШ-ын пургон машинд засвар үйлчилгээг хийхэд | 1.000.000 |
| 3 | 4.1.9 Батлан хамгаалах үйл ажиллагааг, орон нутагт хэрэгжүүлэхэд идэвхи санаачлагатай ажилласан иргэн, албан тушаалтныг урамшуулах | а/ Мөнгөн төлбөр төлүүлэхэд идэвхитэй оролцсон албан тушаалтан | 250.000 |
| | | б/ Цэрэг татлагыг чанартай сайн явуулсан, хяналтын тоо биелүүлсэн албан тушаалтан | 250.000 |
| | | в/ Цэргийн тоо бүртгэл чанартай сайн явуулсан албан тушаалтан | 250.000 |
| | | г/ МУ-ын батлан хамгаалах бодлогын үндэс болон батлан хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчилахад | 250.000 |
| Нийт | | 15.681.900 төгрөг | |

